



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

“ШУУРХАЙ ШТАБ”-ЫН ЦАХИМ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын 57 дугаар цахим хурал 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 15:00 цагт 66,6 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ

Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд Нийслэл, дүүргийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар авч хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, журмын хавсралтаар батлагдсан төрийн байгууллагын үйл ажиллагааны горим, хуулийн этгээдийн үйл ажиллагааны горимын шар түвшинд мөрдөгдөх зохицуулалтад хяналт тавьж ажиллахыг;

2. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, үйл ажиллагаа нь нээгдсэн аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдөгдөх тусгай нөхцөл шаардлагыг хэрэгжүүлж ажиллахыг;

3. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам, заавар батлах тухай” 20 дугаар тушаалаар батлагдсан “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Гэр /амрах байр/-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар /Ковид-19/ илэрсэн объектыг хамгаалах түр журам”-ын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллахыг;

4. Дээр дурдсан журмуудын хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гаргаж биелэлтийг хангуулж, дүн мэдээг тухай бүр Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабт өдөр бүр 14:00 цагт ирүүлж ажиллахыг нутгийн захиргааны нийт байгууллагууд, дүүргүүдийн Онцгой комиссын дарга нарт;

5. “Коронавируст халдвар илрүүлэх шинжилгээний цэг, байршил, ажиллах цагийн хуваарийг иргэд олон нийтэд давтамжтайгаар мэдээлж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэст;

6. Бүсчлэн хязгаарлалт тогтоож, Цагдаагийн хамгаалалт авсан /байр, гудамж/ байршлуудыг иргэдэд урьдчилан мэдээлэх, гэрийн ажиглалтад шилжсэн иргэдийн мэдээллийг “CLIX GPS” системийг ашиглан бүртгэлжүүлж, хаяг, байршилдаа байгаа эсэхэд цаг тухай бүр хяналт тавьж, “Шуурхай штаб”-ын цахим хуралд танилцуулж ажиллахыг дүүргийн Онцгой комиссын дарга нарт тус тус даалгаж шийдвэрлэв.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ШУУРХАЙ ШТАБ

